



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Газрын ёс зүйн зөвлөлийн
гишүүдийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх эрх бүхий “Ёс зүйн зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга:

Орлогч дарга

Гишүүд:

Захиргааны хэлтсийн дарга

Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсийн дарга

Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдол хариуцсан ахлах мэргэжилтэн

Хяналт, шинжилгээ үнэлгээ, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Дотоод орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Газрын “Ёс зүйн дүрэм”-ийг байгууллагын хэмжээнд дагаж мөрдүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, гарсан зөрчил, гомдлыг тухай бүрт нь шийдвэрлэн ажиллахыг Ёс зүйн зөвлөл /Дарга/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2020 оны А/53 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ПҮРЭВСҮРЭН

1150500055